



**РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ
ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ**



**РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ДҮРЭМ, ЖУРМЫН ЭМХТГЭЛ**

РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН СУРГАЛТ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү дүрмийн зорилго нь Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн Сургалт арга зүйн зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Сургалт арга зүйн зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Үйлдвэрлэл Урлалын Политехник коллежийн дүрэм, холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3 Сургалт арга зүйн зөвлөл нь сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, заах арга зүйтэй холбоотой асуудлыг хэлэлцэн, чиглэлийг тогтоох, ач холбогдол, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх, удирдлагаар хангах чиг үүрэгтэй.

ХОЁР. СУРГАЛТ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙГ БАЙГУУЛАХ

2.1 Сургалт арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг багш нарын зөвлөгөөний хурлаар хэлэлцэж, захирлын тушаалаар батална.

2.2 Зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

2.3 Сургалт арга зүйн зөвлөлийн дарга нь сургалтын албаны менежер байх ба гишүүдийн 75%-иас доошгүй хувь нь эрдмийн болон мэргэжлийн зэрэг цолтой, мэргэжлийн багш нар байна.

2.4 Сургалт арга зүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга нь сургалт арга зүйн зөвлөлийн хэлэлцэх асуудал, баримт бичгийг боловруулах, бусад гишүүдийг мэдээллээр хангах, хурлыг бэлтгэх, зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

ГУРАВ. СУРГАЛТ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗАРЧИМ

3.1 Сургалт арга зүйн зөвлөл нь судалгаа шинжилгээ, туршилт, бүтээлч ажлыг сургуулийн эрхэм зорилго, хэтийн ба ойрын зорилтуудад нийцүүлэн шийдвэрлэж зохицуулна.

3.2 Судалгаа шинжилгээ, туршилт, уран бүтээлийн ажлын чиглэл, үйл ажиллагааны арга хэлбэрийг чөлөөтэй сонгон хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. СУРГАЛТ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Сургалт арга зүйн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр

нь хуралдаан байна.Сургалтын үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлыг хэлэлцэж санал дүгнэлт, зөвлөмж, шийдвэр гаргана. Үүнд:

421 Сургалт- арга зүй, эрдэм шинжилгээний ажлын зорилго чиглэлийг тогтоож, онол арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгөх

422 Сургуулийн хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл, эрдэм шинжилгээний ажлын явц, үр дүнг тогтмол хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгч онол арга зүйн удирдлагаар хангах

423 Сургалт – судалгаа, эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөөг жил бүр шинэчлэн боловсруулан баталж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих

424 Багш нарын мэргэжлийн зэрэг хүсэх өргөдлийг хүлээн авч, холбогдох журмын дагуу шийдвэрлэх

425 Сургалт явуулж буй мэргэжлүүдийн сургалтын төлөвлөгөө боловсруулах, сургалтын агуулга арга зүй технологийг боловсронгуй болгох, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах

426 Багш нарын тодорхой хувийг сургалт арга зүй, судалгааны ажилд татан оролцуулах, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, боловсролын болон шинжлэх ухааны эрдмийн зэрэг хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

427 Багш нарын бүтээлийн ажил, ном гарын авлага, цахим хичээл, цахим ном, сурах бичгийг хянах, зөвлөгөө өгөх, стандарт мөрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

428 Сургуулийн багш нарт сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга зүй, судалгааны чиглэлээр сургалт семинар зохион байгуулах

429 Багш оюутныг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд татан оролцуулах зорилгоор эрдэм шинжилгээний бага хурлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, илтгэлийн эмхтгэлийг хэвлүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

ТАВ. СУРГАЛТ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ДЭГ, ШИЙДВЭР ГАРГАХ

5.1 Сургалт арга зүйн зөвлөлийн хуралдааныг улиралд нэг удаа зохион байгуулна. Шаардлагатай үед ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.

5.2 Сургалт арга зүйн зөвлөлийн хурлыг гишүүдийн 75%-иас дээш ирцтэйгээр зохион байгуулна.

5.3 Хурлаар хэлэлцсэн асуудлаар шийдвэр гаргаж тэмдэглэл хөтөлнө.

5.4. Сургалт арга зүйн зөвлөлийн шийдвэр нь хурлын тэмдэглэл байна.